



БУЛГАН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БУЛГАН АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН байдал

Monthly bulletin of **STATISTICS**

2018/12

www.bulgan.nso.mn



СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?

www.1212.mn

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН САН

www.nso.mn сайтын
Хэрэглэгчийн бүртгэлд
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

Monstat ezStat
аппликейшн

1900-1212
Лавлах утас

@statistic_mn

Вндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30

Статистик
мэдээлэл



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ
АВИЛГА

ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ
ХҮРГЭНЭ

ГАРЧИГ

Аргачлалын тайлбар.....	2
Товч танилцуулга.....	6
I. 1 Хүн ам.....	14
I. 2 Хөдөлмөр.....	15
I. 3 Нийгмийн халамж.....	16
I. 3 Нийгмийн даатгал.....	16
I. 4 Эрүүл мэнд	17
I. 6 Гэмт хэрэг	18
II.2 Банк, Санхүү.....	19
II.3 Үнэ.....	20
II.6 Аж үйлдвэр.....	25
II.6 Барилга.....	26
II.8 Худалдан авах ажиллагаа.....	27
II.9 Газар өмчлөл.....	32
II.10 Бизнес регистрийн сан.....	32
II.14 Мал аж ахуй.....	34
II.15 Газар тариалан.....	38

Аргачлалын тайлбар

Хөдөлмөр

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхлэгдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхитэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулах, өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд (хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл)-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

Эрүүл мэнд

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиодлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

Аюулт үзэгдэл, осол

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шроон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно. Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга, байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

Гэмт хэрэг

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний ам бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Хүүхэд гэр бүл, нийгмийн эсрэг гэмт хэрэг
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:

-Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдэл дор нь барьсан

-Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан

-Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон

-Уг этгээд хэргээ илчлэн ирсэн

-Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

Төрийн санхүү

Орон нутгийн төсвийн суурь орлого гэж тухайн шатны төсөвт орох татварыг доод хувь хэмжээгээр тооцсон орлого болон татварын бус орлогын нийлбэрийг хэлнэ.

Орон нутгийн суурь зарлага гэж сум, аймаг, нийслэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй холбогдох урсгал болон хөрөнгийн зарлага, нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлыг хэлнэ.

Төсвийн тэнцэл гэж тухайн төсвийн жил, улирлын нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно.

Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна.

Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

Үнэ

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн

өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн томъёог ашиглаж болно.

$$I_p^L = \frac{\sum_{i=1}^n p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^n p_{io} * q_{io}}$$

I_p^L - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлан үе

o - суурь үе

p_{it} - 'i' барааны тайлант үеийн үнэ,

p_{io} - 'i' барааны суурь үеийн үнэ,

q_{io} - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ,

\sum - нийлбэрийн тэмдэг

Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн

тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Ерөнхий тэмдэглэл

I. Саруудыг ром тоогоор тэмдэглэв (I, II, III, IV, V, ... гэх мэт)

Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-X зэргээр илэрхийлэв.

II. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй

III. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Хүн ам

2018 оны байдлаар иргэний бүртгэлд шинээр төрсөн 1236 хүүхэд, нас барсан 379 хүний бүртгэлийг бүртгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс шинэ төрсөн хүүхэд 3 буюу 0.3 хувиар буурсан бол, нас баралт 9 буюу 2.3 хувиар буурчээ.

Зураг I.1.2

Бүртгэгдсэн төрөлт, нас баралт



2018 байдлаар 1109 хүн шилжин ирж, 1165 хүн шилжин явсан нь өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн хүн 31 буюу 2.7 хувиар, шилжин явсан хүн 157 буюу 13.7 хувиар тус тус буурсан байна.

Зураг I.1.3

Бүртгэгдсэн шилжих хөдөлгөөн



I.2 Бүртгэлтэй, ажилгүй иргэн

Аймгийн хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэн 1081 болсны 527 нь эмэгтэй байна. Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй иргэдийн 0.5 хувийг магистр болон докторын боловсролтой, 19.8 хувийг бакалаврын болон дипломын боловсролтой, 3.4 хувийг тусгай мэргэжлийн дунд, 4.3 хувийг техникийн болон мэргэжлийн, 55.9 хувийг бүрэн дунд боловсролтой, 12.1 хувийг суурь боловсролтой, 3.4 хувийг бага боловсролтой, 0.6 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.

Зураг I.2.1

Ажлын шинэ байранд болон ажилд зуучлагдан орсон иргэд



Аймгийн хэмжээнд ажил хайгч иргэдийн 15.0 хувийг 15-24 насны, 38.9 хувийг 25-34 насны, 23.0 хувийг 35-44 насны, 17.6 хувийг 45-54 насны, 4.5 хувийг 55-59 насны, 0.9 хувийг 60-аас дээш насны хүмүүс эзэлж байна.

Зураг I.2.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр



I.3. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2018 оны жилийн эцсийн байдлаар 9729.3 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 2936.2 сая төгрөг буюу 23.2 хувиар буурч, зарлага 36380.5 сая төг болж өмнөх оны мөн үеэс 935.6 сая төг буюу 2.6 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс буурсан шалтгаан нь эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлага шивэгдээгүйтэй холбоотой.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого өмнөх оны мөн үеэс 653.9(8.8%) сая төгрөгөөр өсч, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 24.5(4.3%) сая төгрөгөөр тэтгэмжийн даатгалын сангийн орлого 86.3(8.9%) сая төгрөгөөр, ажилгүйдлын даатгалын сангийн орлого 17.4(8.5%) сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2018 оны жилийн эцсийн байдлаар 36380.5 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 33.4(6.2%) сая төгрөгөөр буурсан хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн зарлага 4325.8(14.5%) сая төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 133.8(10.9%) сая төгрөгөөр, өссөн нь голлон нөлөөлөв.

Нийгмийн халамж

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2018 оны жилийн эцсийн байдлаар 14123 хүн 5056.3 сая төгрөгийн тэтгвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 191.4 сая.төг буюу 3.9 хувиар өсч, харин нийгмийн халамжийн тэтгэвэрт 1203 хүн хамрагдаж 1815.6 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 158.4 сая.төг буюу 9.6 хувиар өссөн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2018 оны жилийн эцсийн байдлаар 9557 хүн хамрагдсаны 17.5 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 21.1 хувь ахмад настан, 4.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 56.4 хувь хүнс тэжээл хөтөлбөр хамрагдсан байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 1918.9 сая.төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 374.5 сая.төг буюу 24.2 хувиар өссөн байна.




1.4 Эрүүл мэнд

Аймгийн хэмжээнд 2018 оны 3-р улирлын байдлаар 616 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 623 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 14 буюу 2 хувиар, амьд төрсөн хүүхдийн тоо 14 буюу 2 хувиар тус тус өссөн байна.

Зураг 1.4.1


Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд,



Нялхасын эндэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 13 гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал 1.4 дахин өссөн байна.

Зураг 1.4.2


Эндсэн хүүхэд



Халдварт өвчнөөр өвчлөгсөд 2018 оны жилийн эхний хагас жилийн байдлаар 357 болж, өмнөх оны мөн үеийнхээс 123 тохиолдол буюу 26 хувиар буурсан байна. Нийт халдварт өвчнөөр өвчлөгсдийн 129 буюу 36 хувь нь амьсгалын замын халдварт өвчин, 145 буюу 40 хувь нь бэлэгсийн замын халдварт өвчнөөр өвчилсөн байна.

Зураг 1.4.3

Халдварт өвчнөөр өвчлөгсөд




- Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 40 бүртгэгдэж 81.8 хувиар
- Хөдөлгөөний аюулгүй байдал тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30 бүртгэгдэн 1 хэрэгээр буюу 3.1 хувиар
- Хүнийг алах гэмт хэрэг 3 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 50 хувиар
- Мал хулгайлах хэрэг 37 бүртгэгдэж 4 хэргээр буюу 12.1 хувиар тус тус өссөн байна.
- Залилах гэмт хэрэг 5 бүртгэгдэж 4 хэргээр буюу 44.4 хувиар
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 144 бүртгэгдэж 13 хэргээр буюу 8.2 хувиар
- Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 94 бүртгэгдэж 26 хэргээр буюу 21.6 хувиар тус тус буурсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол
Гэмт хэргийн улмаас нийт иргэд , аж ахуй нэгж байгууллагад 1088.4 сая төгрөгний хохирол учирснаас иргэдэд 924.4 сая төгрөгний хохирол учирсан байна. Үүнээс бүртгэлд мөрдөн байцаалтын шатанд 620.2 сая төгрөг буюу 57 хувийн хохирлыг нөхөн төлүүлж ажилласан байна.

Зураг I.6.2


Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, жил бүрийн 4-р улирлын байдлаар



Гэмт хэргийн улмаас 17 хүн нас барсан ба өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.5 хувиар буурсан байна. Бусдыг амиа хорлоход хүргэсэн гэмт хэргийн улмаас 5 хүн, хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 7 хүн, бусад хэргийн улмаас 5 хүн амь насаа алдсан байна.

Зураг I.6.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан, жил бүрийн 4-р байдлаар



Хэргийн өнгөөр нь авч үзвэл: Гэмт хэргийн улмаас 131 хүн гэмтсэн нь ХЭМХБЭГХ-ийн улмаас 103, ХАБТХАЖЭГХ-ийн улмаас 22 хүн, бусад хэрэгийн улмаас 6 хүн гэмтсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 14.3 хувиар буурсан байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 55 бүртгэгдэж 8 хэргээр буюу 12.6 хувиар буурсан.

Нийт 27 хэргийг бүлгээр үйлдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 5 хэргээр буюу 22.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

178 гэмт хэрэгт 261 хүн холбогдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8 хүнээр буюу 2.9 хувиар буурсан байна.

2018 оны 12-р сарын байдлаар 20988 зөрчилд 759.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна. Гудамж талбайд хэвийн бус явж орон гэртээ агсан согтуу тавьсны улмаас 533 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеийхээс 17 хүнээр буюу 3.1 хувиар буурсан байна. Захиргааны журмаар 179 хүнийг баривчилж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож эрхээ хасуулж, торгуулсан 244 иргэн байна.

I.7 Аюулт үзэгдэл осол

Аюулт үзэгдэл, осол 2018 оны жилийн эцсийн байдлаар 79 удаа гарч, 10 хүн амь насаа алдаж, шатсан гэр, орон сууц, авто машины тоо 35 удаа гарсан байна. Мөн аюулт үзэгдэл, ослын тохиодлын тоо 79 удаа гарсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34.7 хувиар буурч, харин объектын гал түймэр 35 удаа гарсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5.4 хувиар буурсан байна.

Зураг I.7.1

Аюулт үзэгдэл, осол болон объектын гал түймрийн тоо, оноор





II. Эдийн засгийн үзүүлэлт

II.1 Аймгийн төсөв

Аймгийн төсвийн нийт орлого 2018 жилийн эцсийн байдлаар 58369 сая төгрөг, зарлага 57008 сая төгрөг болж, аймгийн төсвийн нийт тэнцэл 1361.9 сая төгрөгний эерэг гарлаа.

Зураг II.1.1


Аймгийн төсвийн орлого, зарлага сая төг



Орон нутгийн төсвийн орлогын 38.5 хувийг татварын орлого, 5 хувийг татварын бус орлого, 56.3 хувийг улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг эзэлж байна. Төсвийн зарлага 2018 оны байдлаар 57007.5 сая.төг болоход 77 хувийг бараа ажил үйлчилгээний зардал, 11.8 хувийг урсгал шилжүүлгийн зардал эзэлж байна.

Зураг II.1.2

Аймгийн төсвийн өр, авлага сараар




Нийт өр 57.7 сая төгрөг байна. Өр өмнөх сараас 404.6 сая, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2.0 сая төгрөгөөр буурсан байна. Баяннуур, Булган, Гурванбулаг, Тэшиг, Хутаг-Өндөр сумын орон нутгийн төсөвт байгууллагууд өртэй гарсан байна. Аймгийн төрийн сангаар үйлчлүүлэгч төсвийн байгууллагын 22396 ширхэг гүйлгээгээр 60.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

II.2 Банк, санхүү

Аймгийн арилжааны банкнуудын 4-р улирлын мэдээгээр 276636.7 сая төгрөгийн гүйлгээний орлого орж, 141348.2 сая төгрөгийг гүйлгээнд гаргажээ. Иргэдийн хувийн хадгаламж 39554.6 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өссөн байна.


Зураг II.2.1

Иргэдийн хадгаламж /сая.төг/



Зураг II.2.2

Хадгаламж эзэмшигчийн тоо /сая.төг/




II.3 Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 5.4 хувиар, сарын эхнээс 5.4 хувиар, өмнөх сарынхаас 0.5 хувиар өссөн байна.

Зураг II.3.1

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, хувь, 2018 12 сар, (өмнөх сар=100%)




Хүснэгт II.3.1

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2018 оны 12 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2018 XII 2017 XII	2018 XII 2017 XII	2018 XII 2018 XI
Ерөнхий индекс	100.0	105.4	105.4	100.5
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	102.6	102.6	101.9
Солгоуруулах ундаа, тамхи	3.2	101.4	101.4	100.1
Хувцас, бөс, бараа, гутал	16.1	103.0	103.0	100.3
Орон сууц, ус, цахилгаан, шуудан	12.3	100.7	100.7	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	103.8	103.8	100.8
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	3.6	121.9	121.9	100.6
Тээвэр	12.2	114.5	114.5	99.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	102.3	102.3	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	124.1	124.1	102.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	101.7	101.7	99.2

Зураг II.3.2


Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн индекс, (2015=100)

**II.4 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ**

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2018 оны жилийн эцсийн байдлаар үхрийн 1.8-2.3 м урттай шир 9.0 мян.төгрөг, 2.3 м-с дээш урттай шир 13.5 мян. төгрөг, адууны шир 10.5 мян.төгрөг, ямааны арьс 30.0 мян.төгрөг, хонины нэхий зах зээлд нийлүүлэлт байхгүй болсон байна. Өмнөх оны мөн үеийнхээс үхрийн 1.8-2.3 метрийн урттай шир 70 хувиар, 2.3 метрийн урттай шир 65.4 хувиар, адууны шир 52.3 хувиар тус тус буурсан байна.

II.5 Малын дундаж үнэ

Малын дундаж үнэ: 2018 оны жилийн эцсийн байдлаар тэмээ 900.0 мян.төг, адуу 700.0 мян.төг, үхэр 863.0 мян.төг, хонь 126.0 мян. төг, ямаа 98 мян.төг болж буюу өмнөх оны мөн үеийнхээс тэмээ 4.3 хувиар, адуу 14.7 хувиар, үхэр 10.8 хувиар, хонь 13.6 хувиар, ямаа 24.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**II.6 Аж үйлдвэр**

Аймгийн аж үйлдвэрийн газрууд 2018 оны 4-р улирлын байдлаар 7000.5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 9512.3 сая төгрөгийн борлуулалт нийсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 1 дахин, борлуулалт 42 хувиар тус тус өссөн байна. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын өсөлтөнд мал, мах бэлтгэлийн “Булган мах маркет”ХХК, “Занадуразорбак”ХХК-ууд мах бэлтгэл болон Интосэ ХХК, Хангайн гурил ХХК гурлын үйлдвэрүүдийн үйлдвэрлэлт жигдэгдэрсэнтэй холбоотой байна.

Зураг II.6.1

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт, борлуулалт

**II.8 Өмчийн газар**

2018 оны жилийн эцсийн байдлаар 6 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж, 2 байгууллага, 6 сумын 8 тээврийн хэрэгсэл, 1 барилга, мод борлуулж, 24.9 сая төгрөгийг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын дансанд төвлөрүүлсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал төвлөрүүлсэн орлого 46.4 хувиар буурсан байна.

II.9 Худалдан авах ажиллагаа

2018 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвөөс 17 төсөл арга хэмжээ буюу 1580.3 сая.төг баталсанаас 1509.5 сая. төгрөгийн гэрээ байгуулсан, орон нутгийн хөгжлийн сангаас 10 төсөл арга хэмжээ буюу 657.1 сая.төгрөг батлагдсанаас 635.7 сая.төгрөг, авто замын сангаас 6 төсөл арга хэмжээ буюу 295.0 сая.төгрөг батлагдсанаас 256.4 сая.төгрөг, байгаль хамгаалах сангаас 41 төсөл арга хэмжээ буюу 3389.9 сая. төгрөг батлагдсанаас 3203.4 сая.төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын сангаас 5 төсөл арга хэмжээ буюу 3551.5 сая.төгрөг

батлагдсанаас 3428.8 сая төгрөгийн тус тус гэрээ байгуулсан байна. Нийт 79 төсөл арга хэмжээ буюу 9473.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж баталсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал төсөл арга хэмжээ 2.5 дахин, батлагдсан төсөв 2.1 дахин өссөн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт

II.10 Газар өмчлөл

2018 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд газар өмчлөхөөр 990 иргэн хүсэлтээ гаргасаны 106 иргэн буюу 10.7 хувь нь одоо эзэмшиж, ашиглаж байгаа хашааныхаа газрыг өмчилж авах, 884 иргэн буюу 89.3 хувь нь шинээр газар өмчилж авах хүсэлт гаргасан байна. Хүсэлт гаргасан нийт иргэдийн хүсэлтийн 77.9 хувь шийдвэрлэж, 89.2 га газрыг өмчлүүлсэн байна.

Иргэдийн өмчлөлд шилжсэн газрын 13.1 га буюу 14.7 хувь нь одоогийн эзэмшиж байсан газар нь, 76.1 га буюу 85.3 хувь нь шинээр олгогдсон газар байна.



II.13 Тээвэр

Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг: 2018 оны эхний 4-улирлын байдлаар нийт 9486 тээврийн хэрэгсэл үзлэг оношилгоонд хамрагдсан байна. Үүний 4696 нь суудлын автомашин, 3895 нь ачааны автомашин, 190 автобус, 476 мотоцикл, 79 нь чиргүүл, тусгай зориулалтын бусад 150 байна.



II.14 Хөдөө аж ахуй

Малын тоо

Мал тооллогын урьдчилсан дүнгээр 2018 оны жилийн эцэст манай аймаг мал сүргийн нийт дүн 3305.5 мянган толгойд хүрч, 2017 оныхоос 1.7 хувь буюу 56.1 мянгаар буурлаа. Урьдчилсан дүнгээр адуу 17.8 мянга буюу 6.8 хувиар, үхэр 28.6 мянга буюу 10.1 хувиар, хонь 16.2 мянга буюу 0.9 хувиар тус тус буурсан бол тэмээ 15 толгой буюу 1.1 хувиар, ямаа 6.5 мянга буюу 0.6 хувиар өссөн байна.

Нийт мал сүргийн дотор адуу 7.4 хувь, үхэр 7.7 хувь, тэмээ 0.04 хувь, хонь 53.8 хувь, ямаа 31.06 хувийг тус тус эзэлж, өмнөх оныхоос ямааны эзлэх хувь 0.7 пункт, хонь 0.4 пунктээр өсч, адуу 0.4 пункт, үхэр 0.7 пунктээр тус тус буурсан бол тэмээний эзлэх хувьд өөрчлөлт орсонгүй.

Малчин өрх


Аймгийн хэмжээнд 2018 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 10683 өрх тоологдсон байна. Үүний 77.7 хувь буюу 8296 малчин өрх нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг ба 22.3 хувь буюу 2387 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна. 2018 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 13797 малчид ажиллаж байна. Малчдын 41.1 хувь нь буюу 5675 нь эмэгтэй малчид байна. Малчдыг насны бүлгээр авч үзвэл 27.4 хувь нь 15-34 насны, 59.2 хувь нь 35-59 насны, 13.4 хувь нь 60-с дээш насны хүмүүс байна.

Малчин өрх

Том малын зүй бусын хорогдол 2018 оны 3-р улирлын байдлаар 104.5 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 41.0 мян.толгой мал буюу 64.6 хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 15.7 мянга буюу 15.0 хувь, үхэр 22.3 мянга буюу 21.35 хувь, хонь 38.3 мянга буюу 36.64 хувь, ямаа 28.2 мянга буюу 27.0 хувь, тэмээ 12 буюу 0.01 хувь буюу оны эхний малын 3.1 хувь нь тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын дийлэнх 63.6 хувийг ямаа, хонь эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Могод сум 25.6 хувийг, Гурванбулаг сум 19.9 хувь, Хишиг-Өндөр сум 12.8 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.

Зураг II.14.1

Малтай өрх, малчин өрхийн тоо



Мал төллөлт, төл бойжилт

Аймгийн хэмжээнд 2017 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1520.9 мянган хээлтэгч малын 1079.5 мянга буюу 71.0 хувь нь 2018 оны жилийн эцсийн байдлаар төллөсөн байна. Эм ямааны 69.6 хувь, эм хонины 74.3 хувь, ингэний 53.8 хувь, үнээний 63.8 хувь, гүүний 55.8 хувь төллөжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулвал мал төллөлт 14.6 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.


Гарсан төлийн 94.9 хувь буюу 1045.3 мянган төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй 1.2 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Зүй бусын хорогдол

Том малын зүй бусын хорогдол 2018 оны жилийн эцсийн байдлаар 115.9 мян.толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 30.5 мян. толгой мал буюу 35.6 хувиар өссөн байна. Нийт хорогдлыг малын төрлөөр авч үзвэл адуу 8.2 мянга буюу 90.7 хувь, үхэр 14.3 мянга буюу 2.4 дахин, тэмээ 7 буюу 1.8 дахин, хонь 1.9 мянга буюу 4.6 хувь, ямаа 6.1 мянга буюу 13.3 хувь буюу оны эхний малын 3.4 хувь нь тус тус хорогдоод байна. Нийт хорогдлын адуу 14.83 хувь, үхэр 20.98 хувь, ямаа 27.05 хувь, хонь 37.13 хувь, тэмээ 0.01 хувийг тус тус эзэлж байна. Хорогдлыг сумаар авч үзвэл Могод сум 25.6 хувийг, Гурванбулаг сум 19.9 хувь, Хишиг-Өндөр сум 12.8 хувийг тус тус эзэлж байгаа нь дийлэнх болж байна.

Зураг II.14.2

Том малын зүй бусын хорогдол



Зураг II.14.3

Том малын зүй бусын хорогдол



II.15 Мал эмнэлгийн үйл ажиллагаа

2018 онд 892.2 мян.толгой малд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний вакцин хийхээр төлөвлөгдснөөс жилийн эцсийн байдлаар 832.5 мян. толгой малд вакцин хийж, 93.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Паразиттах өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 96.9 мян. толгой бод мал, 1278.5 мян.толгой бог мал, 2.2 мян.амьтан, бүгд 1377.6 мян.толгой мал, тэжээвэр амьтанд угаалга, туулгалт, тарилга хийхээр төлөвлөгдснөөс 54.2 мян. толгой бодод, 2240.4 мян.толгой богд, 1.0 мян.толгой тэжээвэр амьтанд хийж, бод мал 55.9 хувь, тэжээвэр амьтан 45.4 хувийн гүйцэтгэсэн бол бог мал 75.2 хувиар давуулан гүйцэтгэсэн байна. Мал амьтдын паразиттах өвчнөөр 937 голомтонд 24.3 мян. толгой мал өвчилж, 24.1 толгой мал эдгэрч, 206 толгой мал үхсэн байна. Мал амьтдын халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 75 голомтонд гарч, 666 толгой мал өвчилж, 83 толгой мал эдгэрч, 570 толгой мал үхэж, 13 толгой малыг устгасан байна. Халдварт өвчний голомтын тоог өмнөх оны мөн үетэй харьцуулвал 36.4 хувиар буурсан бол паразиттах өвчний голомт 15.2 хувиар өссөн байна.

Лабораторийн оношлогоо, шинжилгээнд 132.6 мян.толгой мал, тэжээвэр амьтан, 5439.3 мян.кг мах, махан бүтээгдэхүүн, 120.8 мян.литр сүү, сүүн бүтээгдэхүүн, 246.9 мян. ширхэг арьс, шир, 614.3 мян.кг ноос ноолуур, 98.7 мян.кг дайвар, үзлэгт хамрагдаж, илэрсэн өвчин байхгүй, 100 хувь хэрэгцээнд тохирсон байна. Мах махан бүтээгдэхүүнийг өмнөх мөн үетэй харьцуулвал мах махан бүтээгдэхүүн 2.8 дахин, сүү сүүн бүтээгдэхүүн 4.3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт II.15.1

Мал амьтны өвчин, 3-р улирлын байдлаар

Үзүүлэлт	хэмжих нэгж	Паразит өвчин	Халдварт өвчин
Голомтын тоо	ш	937	75
Өвчилсөн	толгой	24265	666
Үхсэн	толгой	206	570
Эдгэрсэн	толгой	24059	83
Устгасан	толгой	-	13

II.16 Газар тариалан

2018 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 48287.36 га талбайд тариалалт хийсэн байна. Үүнээс үр тариа 42259.1 га, төмс 323.88 га, хүнсний ногоо 149.5 га, техникийн ургамал 4641.2 га, тэжээлийн ургамал 910.5 га, эмийн ургамал 3.1 га талбайд тус тус тариалтыг хийжээ.

Зураг II.16.1


Үр тариа, төмс, хүнсний ногооны тариалсан талбай жил бүрийн эхний хагас жилийн байдлаар



Тариалсан талбай өнгөрсөн оны мөн үеийхээс 1.7 хувиар буюу 271.8 га-гаар буурсан. Үүнээс: үр тариа 733.6 га буюу 1.7 хувь, төмс 59.01 га буюу 15.4 хувь, эмийн ургамал 250.4 га буюу 98 хувь, тус тус буурсан бол, Хүнсний ногоо 3.47 га буюу 2.4 хувь, тэжээлийн ургамал 622.5 га буюу 3.1 дахин, техникийн ургамал 145.2 га буюу 3.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг II.16.2


Тариалсан талбай төрлөөр



2018 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 68387 тн ургац хураасан нь өмнөх оноос 36065.11 тн буюу 2.1 дахин өссөн байна. Үүнээс үр тариа 57811.8 тн, төмс 4362.4 тн, хүнсний ногоо 1234 тн, тэжээлийн ургамал 3512.8 тн, эмийн ургамал 0.2 тн -ыг тус тус хураажээ.

Зураг II.16.3

Хураасан ургац төрлөөр




I.I ХҮН АМ

Хүснэгт I.I.1 Хүн ам, өрх

Сум	Хүн ам				2018 2017	Эрэгтэй				2018 2017	Эмэгтэй				2018 2017
	2015	2016	2017	2018*		2015	2016	2017	2018*		2015	2016	2017	2018*	
Баян-Агт	3052	3119	3218	3248	100.9	1550	1583	1632	1645	100.8	1502	1536	1586	1603	101.1
Баяннуур	1868	1818	1861	1825	98.1	983	969	998	976	97.8	885	849	863	849	98.4
Бугат	2182	2241	2277	2195	96.4	1132	1187	1208	1157	95.8	1050	1054	1069	1038	97.1
Булган	12234	12512	12616	12568	99.6	6014	6104	6125	6150	100.4	6220	6408	6491	6418	98.9
Бүрэгхангай	2726	2832	2888	2864	99.2	1388	1459	1482	1469	99.1	1338	1373	1406	1395	99.2
Гурванбулаг	3133	3176	3219	3285	102.1	1617	1644	1660	1686	101.6	1516	1532	1559	1599	102.6
Дашинчилэн	2803	2941	3037	3004	98.9	1431	1492	1540	1523	98.9	1372	1449	1497	1481	98.9
Могод	2685	2701	2729	2708	99.2	1375	1383	1394	1392	99.9	1310	1318	1335	1316	98.6
Орхон	3482	3584	3595	3465	96.4	1865	1911	1913	1856	97.0	1617	1673	1682	1609	95.7
Рашаант	3141	3165	3215	3246	101.0	1583	1602	1618	1641	101.4	1558	1563	1597	1605	100.5
Сайхан	3575	3648	3662	3545	96.8	1816	1854	1871	1799	96.2	1759	1794	1791	1746	97.5
Сэлэнгэ	3207	3306	3332	3339	100.2	1666	1723	1733	1743	100.6	1541	1583	1599	1596	99.8
Тэшиг	3495	3504	3563	3558	99.9	1786	1782	1820	1809	99.4	1709	1722	1743	1749	100.3
Хангал	4548	4611	4705	4655	98.9	2282	2302	2343	2331	99.5	2266	2309	2362	2324	98.4
Хишиг-Өндөр	3154	3156	3158	3146	99.6	1592	1595	1592	1578	99.1	1562	1561	1566	1568	100.1
Хутаг-өндөр	4729	4835	4952	5033	101.6	2432	2487	2546	2573	101.1	2297	2348	2406	2460	102.2
Нийт хүн ам	60014	61149	62027	61684	99.4	30512	31077	31475	31328	99.5	29502	30072	30552	30356	99.4

Зураг I.I.1 Хүн амын нас хүйсийн суварга 2017 он



I.2 ХӨДӨЛМӨР

Хүснэгт I.2.1 Хөдөлмөр

Үзүүлэлт	2017 XII		2018 XII		2018 XII % 2017 IX	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
Ажил хайгч иргэн /сарын эцэст/	1008	491	1736	798	172.2	162.5
Бүртгэлтэй ажилгүй иргэн /сарын эцэст/	703	356	1081	527	153.8	148.0
Ажилд зуучилсан иргэн /эдийн засгийн салбараар/	1039	484	1394	615	134.2	127.1
ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан, агнуур	232	78	289	100	124.6	128.2
Уул уурхай олборлолт	92	9	90	11	97.8	-
Боловсруулах үйлдвэр	31	16	107	49	345.2	306.3
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	12	1	20		166.7	-
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	8	7	41	33	512.5	471.4
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, холбоо мэдээлэл	5	2	10	1	200.0	50.0
Зочид буудал, байр, сууц болон нитийн хоолны үйлчилгээ	20	14	18	15	90.0	107.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	65	25	32	20	49.2	80.0
Боловсрол	42	29	124	91	295.2	313.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	78	56	37	30	47.4	53.6
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа					-	-
Бусад	454	247	626	265	137.9	107.3
Ажил хайгч иргэн (насны бүлгээр)	703	356	1081	527	153.8	148.0
15-24	100	52	162	79	162.0	151.9
25-34	260	140	421	208	161.9	148.6
35-44	146	78	249	125	170.5	160.3
45-54	142	68	190	98	133.8	144.1
55-59	34	10	49	12	144.1	120.0
60+	21	8	10	5	47.6	-
Ажил хайгч иргэн (боловсролын түвшнээр)	703	356	1081	527	153.8	148.0
Магистр, доктор	4	3	5	3	125.0	100.0
Дипломын болон бакалаврын дээд	138	93	214	140	155.1	150.5
Тусгай мэргэжлийн дунд	24	9	37	20	154.2	222.2
Техникийн болон мэргэжлийн	33	12	46	21	139.4	175.0
Бүрэн дунд	405	200	604	281	149.1	140.5
Суурь	67	29	131	50	195.5	172.4
Бага	23	8	37	11	160.9	137.5
Боловсролгүй	9	2	7	1	77.8	50.0

I.3. НИЙГМИЙН ХАЛАМЖ

Хүснэгт I.3.2 Нийгмийн халамжийн зарлага, хамрагдсан хүн

Үзүүлэлт	Хүний тоо		Олгосон тэтгэвэр, тэтгэмж, мян. төг		2018 XII 2017 XII
	2017 I-XII	2018 I-XII	I-XII	I-XII	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	10844	14123	4864880.6	5056263.0	103.9
Халамжийн тэтгэвэр	1238	1203	1657212.6	1815626.9	109.6
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	4259	3363	1663183.6	1321657.9	79.5
Үүнээс:					
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн	2514	1614	619348.2	215663.4	34.8
Ахмад настныг асарч буй иргэний	1030	1104	619696.7	683594.8	110.3
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг	440	409	252922.1	265507.0	105.0
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг	248	209	152388.9	137988.3	90.6
Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөний	27	27	18827.7	18904.4	100.4
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт	5347	9557	1544484.4	1918978.2	124.2
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт тусламж	1718	2020	313372.1	404733.3	129.2
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	368	434	116589.5	91466.6	78.5
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж	1678	1669	659696.2	664523.4	100.7
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	12	39	2000.0	6820.0	341.0
Хүнс тэжээл хөтөлбөр	1,571	5,395	428257.5	729875.0	
Төрийн өмнөөс гүйцэтгэсэн ажил үйлчилгээ			24569.1	21559.9	87.8

I.3. НИЙГМИЙН ДААТГАЛ

Үзүүлэлт	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2018 I-XII 2017 I-XII
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	10458.6	11998.5	12665.5	9729.3	76.8
Үүнээс:					
Тэтгэврийн даатгалын сан	6788.9	7249.4	7460.9	8114.8	108.8
Тэтгэмжийн даатгалын сан	768.9	825.8	974.8	888.5	91.1
Эрүүл мэндийн даатгалын сан	2204.4	3162	3461.9		0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	513.2	563.9	564	539.5	95.7
Ажилгүйдлийн даатгалын сан	183.2	197.4	203.9	186.5	91.5
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая. төг	29832.3	31482.7	35444.9	36380.5	102.6
Үүнээс:					
Тэтгэврийн даатгалын сан	25577.9	27583.9	29805.9	34131.7	114.5
Тэтгэмжийн даатгалын сан	1130.6	1049.9	1230.4	1364.2	110.9
Эрүүл мэндийн даатгалын сан	2339.1	2259.9	3499.6		0.0
ҮОМШӨ*-ний даатгалын сан	541.8	240.8	540.5	507.1	93.8
Ажилгүйдлийн даатгалын сан	242.9	348.2	368.5	377.5	102.4

I.4 ЭРҮҮЛ МЭНД

Хүснэгт I.4.1 Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр оноор

Үзүүлэлт	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2017/2016
Амаржсан эхийн тоо	985	868	825	778	94%
Амьд төрсөн хүүхэд	991	871	835	785	94%
Эхийн эндэгдэл	-	-	-	-	
Амьгүй төрөлт	4	6	0	5	
Гэрийн төрөлт	6	3	5	2	40%
Нэг хүртэл насандаа эндсэн хүүхэд	17	12	9	13	144%
Перинаталь эндэгдэл	16	10	6	13	217%
Амьд төрсөн 1000 хүүхэд тутмаас 1 хүртэл насанд эндсэн хүүхэд	17.2	13.8	10.8	16.6	154%

Хүснэгт I.4.2 Аймгийн хэмжээнд гарсан халдварт өвчин, өвчний төрлөөр, оноор

Үзүүлэлт	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2017/2016
Нийт гарсан халдварт өвчин	394	753	480	357	74%
Гэдэсний халдварт өвчин	11	4	6	51	850%
Амьсгалын замын халдварт өвчин	138	518	250	129	52%
Байгалын голомтот халдварт өвчин	1	10	16	8	50%
Бэлэгсийн замаар дамжих халдварт өвчин	218	188	182	145	80%
Арьсны халдварт өвчин	39	37	26	24	92%

Хүснэгт I.4.3 Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Сум	18-40 настай хүн			С вирус		В вирус	
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Хамрагдсан хувь	С вирустэй гарсан	Тархалтын хувь	В вирустэй гарсан	Тархалтын хувь
Булган	5028	1880	37.4	88	4.7	84	4.5
Баян-Агт	1281	354	27.6	16	4.5	20	5.6
Баяннуур	757	181	23.9	11	6.1	9	5.0
Бугат	844	136	16.1	4	2.9	2	1.5
Бүрэгхангай	1180	400	33.9	17	4.3	19	4.8
Гурванбулаг	1330	406	30.5	21	5.2	17	4.2
Дашинчилэн	1227	520	42.4	44	8.5	26	5.0
Могод	1061	353	33.3	11	3.1	19	5.4
Орхон	1428	291	20.4	7	2.4	16	5.5
Рашаант	1367	466	34.1	20	4.3	31	6.7
Сайхан	1498	225	15.0	10	4.4	23	10.2
Сэлэнгэ	1393	514	36.9	17	3.3	26	5.1
Тэшиг	1487	305	20.5	45	14.8	42	13.8
Хангал	566	253	44.7	6	2.4	20	7.9
Хишиг-Өндөр	1225	475	38.8	6	1.3	18	3.8
Хутаг-Өндөр	2046	615	30.1	12	2.0	42	6.8
Хялганат	1346	555	41.2	10	1.8	34	6.1

I.5 ГЭМТ ХЭРЭГ

Хүснэгт I.5.1 Бүртгээгдсэн гэмт хэрэг, оноор

Сум	2014 I-XII	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2018 I-XII % 2017 I-XII
Булган	91	59	81	87	98	112.6
Баян-Агт	20	14	12	9	12	133.3
Баяннуур	10	12	5	8	8	100.0
Бугат	22	19	17	27	25	92.6
Бүрэгхангай	16	22	14	20	27	135.0
Гурванбулаг	19	14	11	12	16	133.3
Дашинчилэн	16	22	12	9	7	77.8
Могод	8	8	12	8	9	112.5
Орхон	28	42	26	44	35	79.5
Рашаант	14	15	7	15	10	66.7
Сайхан	19	8	13	15	10	66.7
Сэлэнгэ	13	12	4	23	15	65.2
Тэшиг	7	5	10	11	14	127.3
Хангал	14	6	5	24	12	50.0
Хишиг-Өндөр	19	20	9	19	12	63.2
Хутаг-Өндөр	23	9	24	23	25	108.7
Хялганат	13	10	3	8	8	100.0
Бүгд	352	297	265	362	343	94.8

Хүснэгт I.5.2 Хулгайн гэмт хэрэг, сумаар, оноор

Сум	2014 I-XII	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII
Булган	26	15	27	36	39
Баян-Агт	16	2	5	4	6
Баяннуур	8	9	3	2	1
Бугат	7	4	7	8	5
Бүрэгхангай	2	10	6	3	13
Гурванбулаг	8	4	3	4	6
Дашинчилэн	6	10	6	2	3
Могод	4	1	9	2	5
Орхон	14	18	13	17	13
Рашаант	10	7	3	3	5
Сайхан	16	2	4	9	8
Сэлэнгэ	5	3	1	6	3
Тэшиг	2	2	1	1	4
Хангал		1		3	0
Хишиг-Өндөр	11	6	5	5	2
Хутаг-Өндөр	7	2	8	8	9
Хялганат	3	2		1	1
Бүгд	145	93	101	114	123

Хүснэгт 1.5.3 Сумдын хэргийн илрүүлэлт

Сум	Бүртгэгдэх үедээ сэжигтэн этгээд нь тогтоогдоогүй хэрэг		Яллагдагчаар татаж ял сонгосон хэрэг		Хэргийн илрүүлэлтийн хувь	
	2017 I-XII	2018 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2017 I-XII	2018 I-XII
Булган	28	25	12	14	42.9	56.0
Баян-Агт	5	4	3	3	60.0	75.0
Баяннуур	2	3	1	2	50.0	66.7
Бугат	7	5	4	3	57.1	60.0
Бүрэгхангай	8	11	4	7	50.0	63.6
Гурванбулаг	5	6	3	3	60.0	50.0
Дашинчилэн	2	3	1	2	50.0	66.7
Могод	2	8	1	6	50.0	75.0
Орхон	16	13	7	7	43.8	53.8
Рашаант	6	6	4	2	66.7	33.3
Сайхан	7	7	6	4	85.7	57.1
Сэлэнгэ	8	9	5	5	62.5	55.6
Тэшиг	3	7	0	5	0.0	1.0
Хангал	4	3	2	1	50.0	33.3
Хишиг-Өндөр	6	2	4	1	66.7	50.0
Хутаг-Өндөр	6	7	2	3	33.3	42.9
Хялганат	4	1	2	1	50.0	100.0
Бүгд	119	120	61	69	51.3	57.5

Хүснэгт 1.5.4 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, оноор

Үзүүлэлт	2014 I-XII	2015 I-XII	2016 I-XII	2017 I-XII	2018 I-XII	2018 XII% 2017 XII
	сая төгрөг					
Учирсан хохирол- Бүгд	986.9	108.8	759.8	1346.4	954.4	70.9%
Үүнээс						
Нөхөн төлүүлсэн	586.7	534.7	555	758.3	563.1	74.3%
Нөхөн төлүүлэлтийн хувь	59.4	491.5	73.0	56.3	59.0	104.8%

II.2 БАНК, САНХҮҮ**Хүснэгт II.2.1 Арилжааны банкны мэдээлэл, өссөн дүнгээр**

Үзүүлэлт	Хадгаламж /сая.төг/		2018 I-XII % 2017 I-XII	Хадгаламж эзэмшигчдийн тоо		2018 I-XII % 2017 I-XII
	2017 I-XII	2018 I-XII		2017 I-XII	2018 I-XII	
Төрийн банк	11276.9	11645.9	103.3	13235	14299	108.0
ХААН банк	24489.5	23950.3	97.8	16984	17115	100.8
Хас банк	3615.4	3660.7	101.3	3626	3741	103.2
Капитал банк	188.1	297.7	158.3	211	228	108.1
Нийт дүн	39569.9	39554.6	100.0	34056	35383	103.9

Хүснэгт II.2.2 Арилжааны банкны мэдээлэл, өссөн дүнгээр

Үзүүлэлт	2017 I-XII	2018 I-XII	2018 I-XII 2017 I-XII
Кассын орлого	410.7	1590.8	387.3
Монгол банкны зузаатгалаар			
Кассын цэвэр орлого	25992.7	23849.7	91.8
Кассын зарлага	256.9	964.1	375.3
Монгол банкинд өгсөн			
Кассын цэвэр зарлага	26399.7	23518.7	89.1
Зээлийн өрийн үлдэгдэл	105132.2	132936.4	126.4
Хугацаа хэтэрсэн	1291.0	1139.2	88.2
Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	1.2	0.9	69.8
Чанаргүй зээл	2563.5	2038.1	79.5
Зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	2.4	1.5	62.9
Харилцагчийн тоо	135493	112384	82.9
Зээлдэгчийн тоо /сарын эцэст/	22007	22615	102.8
Иргэд	72437	60023	82.9
ААНэгжүүд	9	23	255.6
Олгосон зээлийн дүн	6227.7	18770.4	301.4
Иргэд	6227.7	18750.4	301.1
ААНэгжүүд	0.0	20.0	
Олгосон зээл /оны эхнээс өссөнөөр/	107815.5	143495.9	133.1
Төлөгдсөн зээл /оны эхнээс өссөнөөр/	97129.2	115691.8	119.1

II.3 ҮНЭ

Хүснэгт II.3.1 Хэрэглээний үнийн ерөнхий индекс, барааны бүлгээр

Бараа, үйлчилгээний бүлгийн нэр	Жин	2018 XII 2017 XII	2018 XII 2017 XII	2018 XII 2018 XI
Ерөнхий индекс	100.0	105.4	105.4	100.5
Хүнсний бараа,ундаа, ус	29.3	102.6	102.6	101.9
Согтууруулах ундаа, тамхи	3.2	101.4	101.4	100.1
Хувцас, бөс бараа гутал	16.1	103.0	103.0	100.3
Орон сууц, ус цахилгаан,түлш	12.3	100.7	100.7	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.7	103.8	103.8	100.8
Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	121.9	121.9	100.6
Тээвэр	12.2	114.5	114.5	99.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	102.3	102.3	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	124.1	124.1	102.0
Боловсролын үйлчилгээ	4.7	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	2.6	100.0	100.0	100.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	101.7	101.7	99.2

Хүснэгт II.3.2 Хүнсний гол нэр төрлийн барааны 7 хоногийн ажиглалт 2018 оны 12-р сарын сүүлийн 7 хоног, 2017 оны 12-р сарын сүүлийн 7 хоногтой харьцуулсан

Барааны нэр төрөл		2017 XII/27	2018 XII/26	2017 XII/27 2018 XII/26
"Алтан тариа" гурил	дээд, савласан	1500	1500	100.0
	I зэрэг, задгай	1300	1300	100.0
Талх "Ундрах" аймгийн үйлвэр		1100	1100	100.0
Цагаан будаа		2500	2500	100.0
Элсэн чихэр		2500	2000	80.0
Сүү	Задгай	2000	2000	100.0
	"Цэвэр сүү"	2700	2700	100.0
Ургамлын тос, "Кларина"		4300	4100	95.3
Мах	Үхрийн	5500	7000	127.3
	Хонины	4500	6500	144.4
	Адууны	4500	6500	144.4
	Ямааны	3500	4500	128.6
Ногоо	Төмс /монгол/	1500	1000	66.7
	Лууван /монгол/	1500	1500	100.0
	Байцаа /монгол/	1000	1500	150.0
	Манжин /монгол/	1500	1500	100.0
	Сонгино /монгол/	2000	1800	90.0
	Сонгино /хятад/	1500	1500	100
	Сармис	500	400	80.0



Хүснэгт II.3.3 Хүнсний гол нэр төрлийн барааны ажиглалт, оноор, 12-р сарын байдлаар

Барааны нэр төрөл		Хэмжих нэгж	2014	2015	2016	2017	2018	2018 IX 2017 IX
"Алтан тариа" гурил /задгай/	I зэрэг	кг	1200	1300	1300	1350	1300	96.3
	II зэрэг	кг	700	900	1000	1100	900	81.8
Будаа	Цагаан	кг	2300	2400	2450	2467	2400	97.3
	Шар	кг	1700	1900	1900	1900	2150	113.2
Элсэн чихэр		кг	1800	1800	2466	2233	1933	86.6
Хонины мах	ястай	кг	6500	5500	5000	4500	5500	122.2
	цул	кг	6500	5500	5000	4500	5500	122.2
Үхрийн мах	ястай	кг	7500	7000	5000	5000	6500	130.0
	цул	кг	7500	7000	5500	5500	7000	127.3
Адууны мах		кг	5500	5500	4000	5000	6000	120.0
Ямааны мах		кг	4500	4000	3500	3500	4500	128.6
Сүү	задгай	л	1300	1500	1500	2000	1800	90.0
	"Цэвэр сүү"	л	2250	2750	2633	2650	2550	96.2
Байцаа	монгол	кг	800	1000	800	1000	1000	100.0
Лууван	монгол	кг	1000	1000	800	1500	1133	75.5
Манжин	монгол	кг	1500	1500	800	1500	1200	80.0
Төмс	монгол	кг	800	1200	700	1000	1000	100.0
Сонгино	хятад	кг	1500	1500	1500	1500	1517	101.1
Сармис, булцуу		кг	300	300	500	400	400	100.0
Ургамлын тос		л	3500	3600	3866	3867	3667	94.8
Өндөг		ш	420	400	300	350	367	104.9
Талх "Ундрах" орон нутгийн		ш	750	900	1100	1067	1100	103.1


Хүснэгт II.3.4 Нэг литр шатахууны үнэ, 2018 оны 12-р сарын байдлаар

ШТС	АИ 95	АИ 92	АИ 80	Дезил түлш	Газ
Шунхлай		1895	1865	2375	
Тэс		1890	1860	2390	
Магнай трейд	2350	1900	1870	2400	
Петровис					1350
Гиг газ					1250


